



**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2026 он

2

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМАНД ХАМААРАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2026.01.30

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлж, төлөвлөсөн зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах, удирдлагыг бодитой мэдээллээр хангахад оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар баталсан журмын “Хяналт-шинжилгээний арга зүй” болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнг тооцох аргачлалыг ашиглан хувиар илэрхийлсэн болно. Аргачлалд ашиглагдсан томъёог зургаар оруулав.

Зураг 1:

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} - 100\%$$

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хамаарах нийт арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн дундаж 92.6 хувьтай буюу үр дүнтэй хэрэгжиж байна.

- ✓ 85 хувь ба түүнээс дээш – “Үр дүнтэй” - 11 арга хэмжээ энэ ангилалд хамрагдсан бөгөөд зорилтот түвшинд бүрэн хүрсэн, эсхүл түүнд дөхсөн, бодит үр нөлөө гарсан байна.
- ✓ 60–84 хувь – “Үр дүн хүлээгдэж байгаа” - 4 арга хэмжээ байна. Хэрэгжилт бодитой ахицтай боловч зарим дэд ажил, зохион байгуулалт, үр нөлөөний хэсэг дараагийн шатанд шилжсэн байна.
- ✓ Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй -4 арга хэмжээ нь хэрэгжилтийн хугацаа хараахан болоогүй тул үнэлгээнд хамруулаагүй болно.

3.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд гарсан эерэг үр дүнтэй арга хэмжээнүүдийн талаар дор дурдав. Үүнд

- ✓ Төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлж, e-Mongolia, e-Business зэрэг системээр дамжуулан иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээний ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлсэн.
- ✓ Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээлэл байршуулах, шинэчлэх ажлыг тогтмол хийж, байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр тодорхой ахицууд гарсан байна.
- ✓ Авлигын эрсдэлийг бууруулах зорилгоор өгөгдөлд суурилсан, цахим хяналтын системүүдийг нэвтрүүлэх, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн үзүүлэлттэй байна.

3.2. Үнэлгээ хийх явцад анхаарах хэд хэдэн асуудал байсныг дор дурдав. Үүнд:

- Зарим арга хэмжээ хугацаандаа бүрэн хэрэгжээгүй, эсхүл дараагийн жилд шилжсэн байна.
- Зөвшөөрөл олголт, шийдвэр гаргалтын зарим процесс бүрэн цахимжиж амжаагүй нь авлигын эрсдэлийг бүрэн арилгахад хүндрэл саад учирч болзошгүй гэж үзэх үндэслэлтэй байна.
- Иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоог бодитой хангахтай холбоотой арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байх тул цаашид сайжруулж ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

3.3. Мөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хамтран хэрэгжүүлэх, үндсэн хэрэгжүүлэгчтэй уялдаа холбоотой ажиллах шаардлагатай гэж үзэж буй 1 арга хэмжээ байна. Тодруулбал:

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилт 2 “Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлэх”-ын 2.3-т “Нийтийн албан тушаалтан зарлагаа мэдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, татварын болон төрийн бусад мэдээлэлтэй уялдуулан хяналт тавих цахим системийг хөгжүүлэх” гэсэн төлөвлөлт байх бөгөөд .

2.3.2.1 дэх хэсгийн 2.3.2-д “Мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын үйл ажиллагаанд төрийн байгууллагын мэдээллийг бүрэн ашиглаж, эрсдэлд суурилсан цахим систем хөгжүүлэх” үйл ажиллагааны хүрээнд “Мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын үйл ажиллагааны эрсдэлд суурилсан цахим систем хөгжүүлэх” төлөвлөлт бүхий арга хэмжээ туссан бөгөөд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам үндсэн хэрэгжүүлэгч биш тул үнэлгээ буурсан боловч уг арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгчээс Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас зөвлөмж дүгнэлт авч хамтран ажиллах эрх нээлттэй байх тул үндсэн хэрэгжүүлэгч байгууллага цаашид анхаарч хамтран ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

Үнэлгээ хийх боломжгүй буюу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны хуулиар олгогдсон үндсэн чиг үүрэгт хамааралгүй боловч, хамтран хэрэгжүүлэхэд нээлттэй гэж үзэж буй 4 арга хэмжээ байна. Тодруулбал үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас ажлын хэсэг байгуулах, зөвлөмж дэмжлэг хүсэх зэрэг агуулгаар хандсан тохиолдолд эргэх холбоотой ажиллах бүрэн боломжтой арга хэмжээнүүдийг дор дурдав.

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3.2-т “Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх болон хэрэгжилтийг үнэлэхэд иргэн, иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог хангаж иргэнд ээлтэй бодлого, шийдвэр гаргах нөхцөлийг хэвшүүлэх” үйл ажиллагааны 3.2.3-т “Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсголыг зохион байгуулахдаа иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх” хүрээнд

туссан “Нийтийн сонголын тухай хуульд заасан сонголд иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх” арга хэмжээ;

- Хөтөлбөрийн 3.3-т “Төрийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хяналт тавих иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхэд шаардлагатай дэмжлэг бий болгох” зорилтыг дэвшүүлсэн байх бөгөөд 3.3.1-д “Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэхдээ баримт, судалгаа, зөвлөмжийг үндэслэн тэдгээрийн бодит оролцоог хангах” үйл ажиллагаа төлөвлөгдсөн байна. Энэ хүрээнд “Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэх хуулийн ажлын хэсэгт ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх” арга хэмжээ;

- Дээрх төлөвлөлтийн хүрээнд авлигатай “тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ”;

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4-т “Хувийн хэвшилд авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлэх” төлөвлөлтийн 4.2.4 “Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын байгууллагаас шаардах Комплаенсын шаардлагыг хангах” үйл ажиллагааны хүрээнд туссан “Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын байгууллагаас шаардах Комплаенсын шаардлагыг хангах зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдэд ISO 37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоог нэвтрүүлэх” арга хэмжээ тус тус байна.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд (ЦХИХХЯ) хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс харахад тус яам нь хөтөлбөрийн зорилго, чиглэлтэй нийцсэн бодлогын болон үйл ажиллагааны тодорхой ахиц дэвшил гаргасан байна. Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 92.6 хувьтай буюу “үр дүнтэй” түвшинд хүрсэн нь цахим засаглал, ил тод байдал, хяналтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр бодит үр нөлөө бий болсныг харуулж байна.

Тодруулбал, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлж, e-Mongolia, e-Business зэрэг нэгдсэн системүүдийг ашиглан иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээний ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлсэн нь авлигын эрсдэлийг бууруулахад чухал хувь нэмэр оруулжээ. Мөн Нээлттэй мэдээллийн нэгдсэн системд (shilen.gov.mn) мэдээлэл тогтмол байршуулах, шинэчлэх замаар байгууллагын ил тод байдлыг хангах, олон нийтийн мэдээлэл авах эрхийг бодитоор хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн нь хөтөлбөрийн зорилтод нийцсэн эерэг үр дүн гэж дүгнэхээр байна. Үүнээс гадна өгөгдөлд суурилсан, цахим хяналтын шийдлүүдийг нэвтрүүлэх, сайжруулах арга хэмжээнүүд хэрэгжсэн нь авлигын эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэхэд чухал алхам болсон байна.

Гэсэн хэдий ч үнэлгээний явцад тодорхой анхаарах шаардлагатай асуудлууд илэрсэн болно. Зарим арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа бүрэн хэрэгжиж амжаагүй, эсхүл дараагийн жилд шилжсэн нь хэрэгжилтийн төлөвлөлт, уялдаа холбоог илүү нарийвчлан сайжруулах шаардлагатайг харуулж байна. Түүнчлэн зөвшөөрөл олголт, шийдвэр гаргалтын зарим үйл явц бүрэн цахимжиж амжаагүй байгаа нь авлигын эрсдэлийг бүрэн арилгахад тодорхой хүндрэл учруулж болзошгүй нөхцөл хэвээр байгааг илтгэж байна. Иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн бодит оролцоог хангахтай

холбоотой арга хэмжээний хэрэгжилт харьцангуй сул байгаа нь бодлого боловсруулах, хэрэгжилтийг үнэлэх үйл явцад олон талын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатайг онцолж байна.

Мөн ЦХИХХЯ-ны үндсэн чиг үүрэгт шууд хамаарахгүй боловч хамтран хэрэгжүүлэх боломжтой зарим арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд үнэлгээ хийх боломж хязгаарлагдмал байсан ч цаашид үндсэн хэрэгжүүлэгч байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах, зөвлөмж, техникийн дэмжлэг үзүүлэх боломж бүрэн нээлттэй байна.

Иймд цаашид хэрэгжилтийн төлөвлөлтийн нарийвчлалыг сайжруулах, хугацаа, хариуцлагын тогтолцоог тодорхой болгох, цахим шийдлүүдийн бүрэн нэвтрэлтийг хангах, иргэний нийгэм, олон нийтийн оролцооны бодит үр нөлөөг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллах нь зүйтэй гэж дүгнэж, цаашид авах арга хэмжээг боловсруулав.

Тав.Цаашид авч хэрэгжүүлэх зөвлөмж

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гарсан дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. Төлөвлөлтийн чанарыг сайжруулах: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт туссаны дагуу хийж хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх;

2. Хэрэгжилтийн хариуцлага, хяналтыг чангатгах: Хэрэгжилт удаашралтай болон эхлээгүй ажлуудад онцгой анхаарч, хариуцсан нэгж, албан тушаалтныг тодорхойлон, хугацаа, агуулгын уялдааг ханган ажиллах.

3. Тайлагналын чанар, үр дүнд суурилсан байдлыг хангах: Төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг мөрдөж, шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний тоон, чанарын үзүүлэлт болон нийгэм, эдийн засагт үзүүлсэн эерэг нөлөөг тодорхой тусгах.

4. Салбар хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх: Төлөвлөгөөнд туссан салбар хоорондын уялдаа шаардсан ажлуудад анхаарч, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжилтийг зохион байгуулах.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, нэгжийн албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй болно.

**Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хамаарах арга хэмжээний биелэлт**

Д/д	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Санхүүжилт	Зорилгот түвшин 2025 он	Үндсэн эсэх	Хэрэгжилт ил хувь	Хэрэгжилт	Хүрсэн түвшин
2. Олон нийтийн итгэлийг хүлээн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлнэ.										
2.3. Нийтийн албан тушаалтан зарлагаа мэдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, татварын болон төрийн бусад мэдээлэлтэй уялдуулан хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ.										
1	2.3.2. Мэдүүлгийн бүрдүүлэлт, шалгалтын ажиллагаанд байгууллагын мэдээллийг ашиглаж, суурилсан цахим систем хөгжүүлнэ.	2.3.2.1. Мэдүүлгийн бүрдүүлэлт, шалгалтын ажиллагааны суурилсан цахим систем хөгжүүлэх.	Цахим системээр зохион байгуулагдсан мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын үйл ажиллагаа	-	-	100	Үгүй	80%	Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банк хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Дэлхийн банкны зээлийн санхүүжилтээр Ухаалаг засаг төслийг хэрэгжүүлж, хариуцагчаар тус яам ажиллаж байгаа бөгөөд Авлигатай тэмцэх газрын хариуцдаг Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн системийг шинэчлэх, тоног төхөөрөмжийг сайжруулах төслийг АТГ-тай хамтран хэрэгжүүлж байна. *Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем болон тоног төхөөрөмж" төслийн гүйцэтгэгчээр Ай ти зон ХХК шалгарсан ба 2025 оны жилийн эцсийн байдлаар Мэдүүлэг бүрдүүлэлт, хяналт шалгалтын систем, түүний өгөгдлийн сам, техник хангамжийг бүрэн шинэчилж, Авлигатай тэмцэх газрын iad.iaac.mn, search.iaac.mn, smart.iaac.mn, хасcom.iaac.mn зэрэг шинэчилсэн системүүд ажиллахад бэлэн болсон.	
2.5. Төрийн үйл ажиллагааны мэдээллийг цахимжуулах замаар иргэдийн мэдэх эрхийг баталгаатай эдлүүлнэ.										
2	2.5.1. Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2.5.1.1. Төрөөс хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээ	897	786 Улсын төсөв, бусад эх үүсвэр	1070	Тийм	100%	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia.mn) буюу төрийн үйлчилгээний e-Mongolia.mn портал, операторын систем, киоск машин, мобайл аппликейшн, хуулийн этгээдэд зориулсан e-business.mn платформ, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын lavlaаа.e-mongolia.mn гэсэн 6 сувгаар дамжуулан төрийн 88 байгууллагын 1268 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэж байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia"-г 2020 оны 10 дугаар сард ашиглалтад оруулж, 2020 онд төрийн 23 байгууллагын 181 үйлчилгээ, 2021 онд 59 байгууллагын 606 үйлчилгээ, 2022 онд 69 байгууллагын 897 үйлчилгээ, 2023 онд 86 байгууллагын 1033 үйлчилгээг, 2024 онд 86 байгууллагын 1,250 үйлчилгээг, 2025 онд төрийн 88 байгууллагын 1268 үйлчилгээг, бүртгэлтэй 2,093,818 хэрэглэгчид 98,485,751 удаа дамжуулж, 2020 оноос хойших хугацаанд нийт 1.9 их наяд төгрөгийн шууд бус хэмнэлт (цаас, цаг хугацаа, унааны зардал)-ийг бий болгосон байна.	1268
3	2.5.2. Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, хуулийн хэрэгжилтэд хоёр жил тутам үнэлгээ хийж олон нийтэд ил тод мэдээлнэ.	2.5.2.1. Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах	Олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээлэл	3		100	Үгүй	100%	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч байгууллага байнга ил тод, нээлттэй байлгах 67 төрлийн мэдээллийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны цахим хуудас (www.mddic.gov.mn)-д нээлттэй байршуулж, Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлсэн. Тус яамны нээлттэй мэдээллийн ил тод байдлын 2025 оны 1 дүгээр улирлын үнэлгээ 95.75%, 2 дугаар улирлын үнэлгээ 93.2%, 3 дугаар улирлын үнэлгээ 61.13%, 4 дүгээр улирлын үнэлгээ 98.95%, 2025 оны жилийн дундаж үнэлгээ 87.3% байна. Цахим хуудас хандах: https://shilen.gov.mn/index Нотлох баримт: 4 улирлын үнэлгээ бүхий зураг	
4	2.5.3. Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг шаттайгаар цахимжуулна.	2.5.3.1. Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулах	Цахимаар олгож буй зөвшөөрөл	66	150 Улсын төсөв, бусад эх үүсвэр	100	Тийм	100%	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын А/27 дугаар тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу "Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төрөөс аж ахуйн нэгжтэй харилцах бүхий л үйл ажиллагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "e-Business"-д нэгтгэхээр төлөвлөсөн. Тус ажлыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн Ажил хариуцуулах тухай тушаалыг боловсруулан батлуулж, 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/2379 тоот бичгээр холбогдох байгууллагуудад, 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 02/2412 тоот албан бичгээр харьяа байгууллагуудад тус тус хүргүүлсэн. Холбогдох байгууллагууд нь төлөвлөгөөний дагуу арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2025 оны 12 дугаар сарын байдлаар e-business платформд 832 үйлчилгээ нэвтэрсэн. Зөвшөөрлийн тухай хуульд заасан 254 тусгай зөвшөөрлөөс e-business платформд 44 цахимжиж, 134 линкээр холбогдож, 76 цахим хэлбэрт шилжээгүй, харин 124 энгийн зөвшөөрлөөс 23 цахимжиж, 43 линкээр холбогдож, 58 цахим хэлбэрт шилжээгүй байна. Ингэснээр нийт 378 зөвшөөрлийн 67 зөвшөөрөл цахим хэлбэрт шилжиж, 177 зөвшөөрлийг линкээр холбосон бөгөөд 134 зөвшөөрөл цахим хэлбэрт шилжээгүй байна. Нийт зөвшөөрлийн 64,5 хувь нь цахим хэлбэрт шилжээд байна. Цаашид үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэн e-business платформд холбох ажлууд хийгдэнэ.	244
3. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлнэ.										

3.2. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх болон хэрэгжилтийг үнэлэхэд иргэн, иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог хангаж иргэнд эзлэн боллого, шийдвэр гаргах нөхцөлийг хэвшүүлнэ.									
5	3.2.3. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсголыг зохион байгуулахдаа иргэн иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.	3.2.3.2. Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсголд иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх	Сонсголд оролцсон ажиглагч, оролцогчдын тооны есөлт	5	40 Улсын төсөв, бусад эх үүсвэр	100	Үгүй	Ү.Б	Тус яамнаас Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсгол зохион байгуулаагүй болно.
6	3.2.4. Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн стандартын дагуу ил болгож, иргэн шууд хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.	3.2.4.4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэх	Нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль тогтоомж	1		1	Үгүй	100%	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/268, А/48 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий зөвлөлийн ажиллах журам"-ын 2.2-т заасны дагуу "Зөвлөлийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө", "Үнэлгээний хуваарь"-ийг Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Цахим хөгжил, харилцаа холбооны сайд хамтран баталсан. Төлөвлөгөөнд туссан Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулан Засгийн газрын гишүүдээс санал авч, саналыг нэгтгэн боловсруулж байна. 2026 оны 1 дүгээр улиралд Засгийн газрын хуралдаанд оруулахаар төлөвлөсөн. Тус яамнаас мэдээлэл хариуцагчийн цахим хуудас, мэдээллийн самбар болон бусад мэдээллийн хэрэгслээр түгээсэн нээлттэй мэдээллийн ил тод байдалд үндэслэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.19-д заасан журмын дагуу үнэлгээг хийж ажилласан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу цахим хуудсандаа нээлттэй байршуулах 67 төрлийн мэдээлэлд үнэлгээ хийж Шилэн Индекс-ийг системд нийтэлсэн. 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 4,579 байгууллага бүртгэл үүсгэснээс 2025 оны 1 дүгээр улиралд 1135 байгууллага, 2 дугаар улиралд 1621 байгууллага, 3 дугаар улиралд 1879 байгууллага хуулийн хугацаанд тайлан илгээсэн. 2025 оны III дугаар улирлын байдлаар Төрийн захиргааны төв байгууллага 49.4% (Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 14 яам), Төрийн захиргааны байгууллага 78.08% (33 агентлаг), нийслэлийн Засаг даргын Тамгын газар 74.9% (НЗДТГ, 8 ЗДТГ), нутгийн захиргааны байгууллага 77.09% (21 аймаг) үнэлэгдээд байна.
3.3. Төрийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хяналт тавих иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхэд шаардлагатай дэмжлэг бий болгоно									
7	3.3.1. Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэхдээ баримт, судалгаа, зөвлөмжийг үндэслэн тэдгээрийн бодит оролцоог хангана.	3.3.1.1. Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэх хуулийн ажлын хэсэгт ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	Хуулийн ажлын хэсгийн нийт гишүүдийн тоонд эзлэх иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл	-		10	Үгүй	Ү.Б	Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэх хуулийн ажлын хэсэгт ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ нь тус байгууллагын чиг үүрэгт шууд хамааралгүй болно.

8	3.3.1.4. Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт	-	400 Улсын төсөв, бусад эх үүсвэр	30	Үгүй	30%	<p>Авлигатай тэмцэх газраас 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 03/18879 дугаартай албан бичгээр авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх, үр дүнтэй хяналтын механизмыг сайжруулах зорилгоор "Авлигатай тэмцэхэд олон нийтийн оролцоог хангах нь" хөтөлбөрийг боловсруулан ирүүлж, уг хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа, арга хэмжээнээс сонгон авч, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах талаар мэдэгдсэн.</p> <p>Тус яамнаас "Хууль тогтоомжийн төсөл, төрийн бодлогыг боловсруулах явцад иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах" дэд хөтөлбөрийг сонгож, 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь тайлант онд хэрэгжүүлэх боломжгүй цар хүрээний хувьд урт хугацаандаа хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд тул 2026 онд хэрэгжилтийг хангахаар төлөвлөсөн.</p> <p>Тус яамнаас 2026 оны "Хиймэл оюун, их өгөгдлийг дэмжих жил" болгон зарлаж, 3 хуулийн нэмэлт, өөрчлөлт, 4 анхдагч хуулийн төслийг боловсруулахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд эдгээр хуулийн төслийн хүрээнд олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах, тэдний санал оролцоог тусгахаар төлөвлөсөн.</p> <p>Түүнчлэн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг шийдвэрлэж, яамны худалдан авах ажиллагааны 2026 оны төлөвлөгөөнд 40,000.00 төгрөгийн төсөвт өртөгтэй "Салбарын хууль тогтоомжийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхүйлчилгээ" ЦХИХХЯ/20260603039 арга хэмжээг тусуулавд байна.</p>
9	3.3.1.5. Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, олон нийтийн хяналт хэрэгжүүлэх этгээдийг чадавжуулах	Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн Олон нийтийн хяналтын үйл ажиллагаа	-	210 Улсын төсөв, бусад эх үүсвэр	44	Үгүй	100%	<p>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг мөрдөж ажиллахыг төрийн бүх шатны байгууллагын дарга нарт даалгасны дагуу журмын хэрэгжилтийг хангах хүрээнд уг ажлыг хөндлөнгийн хараат бус этгээдээр гүйцэтгүүлэхээр тус яамны 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, холбогдох гэрээг "Судлаач соно бодлого судалгааны төв" НҮТББ-тай байгуулан ажилласан. Үйлчилгээ үзүүлэгч нь журмын 2.1-т заасан чиглэл, үйл ажиллагааны дагуу Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яам болон түүний харьяа байгууллагууд болох Үндэсний дата төв УТУГ, Радио, телевизийн үндэсний сүлжээ УТУГ, И-Монгол академи УТУГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТУГ, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албан дээр 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд ажиллаж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг гарган хүлээлгэн өгсөн болно.</p> <p>Тайлант онд тус яамнаас хэрэгжүүлэх авлигын эсрэг төлөвлөгөөнд уг дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг тусган тус яамны мэдээ, мэдээллийн ил тод байдлыг хангахаар ажиллаж байна.</p>
4. Хувийн хэвшилд авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлнэ.								
4.2. Шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа авлигын хүчин зүйлсийг арилгана.								
10	4.2.2. Бизнесийн үйл ажиллагаа, шударга өрсөлдөөнд сөргөөр тодорхойлох суурь судалгааг чиглэл бүрээр, үе шаттайгаар зохион байгуулах	Зохион байгуулсан судалгаа	-	100 Улсын төсөв, бусад эх үүсвэр	1	Үгүй	100%	<p>Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлж, "e-Business" системийн хөгжлийн дараагийн шатны зорилт, хэрэгжилтийг хэлэлцэж, бизнес эрхлэгчдийн санал, шийдэл, гарцыг тодорхойлох хэлэлцүүлгийг 2025.10.17, 28 өдрүүдэд болон 11 дүгээр сарын 04, 07-ны өдрүүдэд Эдийн засаг, хөгжлийн яам, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын "Албан бус эдийн засгийг албажуулах төсөл", "И-Монгол академи" УТУГ-тай хамтран зохион байгуулсан.</p> <p>Мөн Дэлхийн банкны хэрэгжүүлж буй дэлхийн улс орнуудын бизнес, хөрөнгө, оруулалтын орчныг үнэлэх зорилго бүхий Business Ready (B-Ready) төслийн дагуу Монгол Улсад аж ахуйн нэгж үйлчилгээ эрхэлэхэд шаардлагатай 83 үйлчилгээний одоогийн нөхцөл байдлыг тогтоож, цахим хэлбэрт шилжсэн болон шилжүүлэх боломжтой төрийн үйлчилгээг тодорхойлж, судалгаа хийсэн.</p>

11	нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлох суурь судалгааг үе шаттайгаар зохион байгуулж, хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.	4.2.2.2. Бизнесийн үйл ажиллагаа, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт	-	350 Улсын төсөв, бусад эх үүсвэр	10	Үгүй	100%	Зөвшөөрлийн нэгдсэн сангаас зөвшөөрлийн хүсэлт гаргасан байгууллага, олгосон байгууллага, шийдвэрлэлтийн төлөв зэрэг мэдээллийг төрд байгаа миний мэдээлэл цэс, Зөвшөөрлийн мэдээлэл цэсээр орохоор Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia)-д хөгжүүлэлт хийн 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн. Зөвшөөрлийн нэгдсэн санд нэвтрүүлсэн зөвшөөрүүдийг e-Business системд "OAuth" системээр дамжуулан нэвтрэлтийг дамжуулан зөвшөөрөл авах боломжийг бүрдүүлэн ажилласан. Бизнес эрхлэгчид ээлтэй цахим үйлчилгээ үзүүлэх хүрээнд "Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төрөөс аж ахуйн нэгжтэй харилцах бүхий л үйл ажиллагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн e-Business платформ"-д нэгтгэх төлөвлөгөөг Цэхим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд батлан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Нийт 25 арга хэмжээг төлөвлөсөн ба e-Business платформын мобайл хувилбарыг 01 дүгээр сарын 30-ны өдөр, портал хувилбарыг 06 дугаар сарын 20-ны өдөр нээнэ. Мобайл хувилбарт хуулийн этгээдийн нэр баталгаажуулах үйлчилгээг хиймэл оюун моделийн шалгууртайгаар гүйцэтгэх бөгөөд энэ нь бизнесийн үйл ажиллагаа, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулахад нөлөө үзүүлэх юм
12	4.2.4. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын шаардлагаас хангах зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдэд ISO 37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоог нэвтрүүлэх	4.2.4.8. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын шаардлагаас хангах зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдэд ISO 37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоог нэвтрүүлэх	Стандарт нэвтрүүлсэн болон нэвтрүүлэхээр ажиллаж байгаа хуулийн этгээд	-	200 Улсын төсөв, бусад эх үүсвэр	5	Үгүй	Ү.Б	Тус байгууллагын эрхлэх асуудалд хамааралгүй болно.

6. Авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

6.4. Шаардлагатай бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

13	6.4.11. Төрийн бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажиллагааг сайжруулна.	6.4.11.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангах	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт	70.1	300	100	Тийм	70%	Тус яамнаас 4 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг төлөвлөн, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн. Үүнээс Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргээд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд тус яам болон яамны харьяа 4 улсын төсөвт үйлдвэрийн газрын олон нийтийн сүлжээн дэх цахим хаягаар тухай бүрд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, энэ талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт мэдэгдэхийг уриалсан ажлуудыг хийгээд байна. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд https://shilen.gov.mn/home цахим хуудаст байрлуулах нээлттэй мэдээллийг хуульд заасан хугацаанд, бүрэн байршуулах ажлуудыг хийгээд байна. ЦХИХХЯ-ны чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 99%, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 99%, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 97%, үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 100%, бусад хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал 96%-ийн гүйцэтгэлтэйгээр нээлттэй ил тод байршаад байна. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах зорилтын хүрээнд яамны албан хаагчдад Авлигатай тэмцэх газрын цахим хуудаст байршсан мэдээллийг тогтмол тухай бүрд линкээр хүргэж ажилласан. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх зорилтын хүрээнд шинээр нийтийн албанд томилогдохоор нэр газар эзтгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар тухай бүрд хянуулж, сонирхлын зөрчил үүсээгүй иргэнийг томилж байсан. Тайлант хугацаанд 92 иргэн, албан хаагчийн хувийн ашиг сонирхлын байдалд дүгнэлт гаргуулсан байна.
----	--	---	---	------	-----	-----	------	-----	---

7. Төсөв, санхүү, аудитын хяналтыг сайжруулан, худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг бууруулна.

7.3. Засгийн газрын өр, тусгай сан, гадаадын зээл, тусламжийн ил тод байдлыг нэмэгдүүлж, менежментийг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

14	7.3.3. Тусгай сангуудын үйл ажиллагааг олон улсын сангийн удирдлагын жишигт нийцүүлж шилэн болгох, эрсдэлийн үнэлгээг тодорхой хугацаанд давтамжтай хийж, аудитын үр дүнгээр нийтийн сонсгол зохион байгуулна	7.3.3.1. Тусгай сангуудын үйл ажиллагааг олон улсын сангийн удирдлагын жишигт нийцүүлж шилэн болгох арга хэмжээ авах	Арга хэмжээ	-	2	Үгүй	80%	ЦХИХХ-ны сайдын багцад хамаарах Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан болон Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь холбогдох хууль, журмын хүрээнд тухай бүр төсөл арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж тус бүрийн Хяналтын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, санал авч Сангийн дарга буюу ЦХИХХ-ны сайдаар батлуулан яамны худалдан авах ажилгааны төлөвлөгөөнд тусгуулан нэгдсэн төлөвлөгөөг https://user.tender.gov.mn/mn/plan/index?year=2025&selGovernorId=164&selClientId=1643000216807&get=1 олон нийтэд нээлттэй байдлаар байршуулаад байна. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нээлттэйгээр нийтэлж, тендер шалгаруулалтыг зохион байгуулдаг бөгөөд тендерт шалгарч гэрээ байгуулсан оролцогчдын мэдээллийг Худалдан авах ажиллагааны цахим системд олон нийтэд нээлттэйгээр мэдээллийг байршуулж, санхүүжилт олгосон мэдээллийг шилэн дансны цахим системд тухай бүр байршуулан ажиллаж байна. Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд мэдээлэл хариуцагч байгууллагаас нээлттэй өгөгдөл, мэдээллийг байршуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангуулах зорилгоор "Нээлттэй мэдээллийн систем" /shilen.gov.mn/-ийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт шилжүүлэн хариуцуулах 2025.09.17-ны өдрийн А/126 тоот тушаал батлагдсан. Засгийн газрын тусгай сангуудаас 2025 оны III улирлын байдлаар нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д А тусгай сан мэдээллээ байршуулж, үнэлгээ хийгдсэн байна.
----	---	--	-------------	---	---	------	-----	---

9. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна

9.2. Олон нийтийг авлигаас ангид байлгах, нийгмийн ёс суртахуумыг дээшлүүлэх зорилгоор үндэсний контентийг бүтээж, түгээгнэ

15	9.2.2. Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, солилцох сувгийг хөгжүүлнэ.	9.2.2.1. Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, солилцох сувгийг хөгжүүлэх	Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд оролцсон соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн салбарт хамаарах хуулийн этгээд, хувь хүн	18	300 Улсын төсөв, бусад эх үүсвэр	28	Үгүй	Ү.Б	1.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia portal) болон e-Mongolia app-аар дамжуулан АТГ-т санал, хүсэлт, гомдол мэдээлэл өгөх суваг нээж, шүгэл үлээгчийг хамгаалах боломжийг бүрдүүлсэн. Мөн төрийн үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх боломж болон түүний ач холбогдлын талаар олон байгууллагын болон харьяа байгууллагын цахим хуудсаар олон нийтэд суртагчлан таниулж байна. 2.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11-д "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална." гэж заасны дагуу ЦХИХХЯам, ГБХНХЯам, ХХЗХороотой журмын төслийг хамтран боловсруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Журам батлах тухайА/53/А/95/А/76 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан.Журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 7204 дугаарт бүртгэсэн.Өргөн нэвтрүүлэг болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчдэд цахим орчин, өргөн нэвтрүүлгийн орчинд хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хортой болон хориотой агуулгыг түгээснээс үүсэх эрсдэлийг таних, мэдээлэх, хариу арга хэмжээ авах цахим сургалт, хэлэлцүүлэг Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдэд 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан.
----	---	--	--	----	----------------------------------	----	------	-----	---

9.4. Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга замаар ёс зүйн төлөвшилийг дэмжинэ

16	9.4.1. Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгоход чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг насны ангилал, орчин үеийн чиг хандлагад нийцсэн байдлаар судалгаанд тулгуурлан боловсруулна.	9.4.1.1 Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт	-	250 Улсын төсөв бусад эх үүсвэр	10	Үгүй	100%	Тус ажлыг хариуцан хэрэгжүүлэх байгууллагаас Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөр ирүүлээгүй учир тус яам НҮБ-ын Хүүхдийн Сан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, "И-Монгол академи" УТҮГ, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монголын хүүхдийн зөвлөлтэй хамтран "Girls in ICT" арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан. Тус арга хэмжээ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйл "Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал"-ын мэдлэг мэдээллийг таниулах, хүүхдийн насны онцлог тохирсон контент, цахим орчинд өөрийн аюулгүй байдлаа хэрхэн хамгаалах, цахим орчны зөв зохистой ёс зүй, цахим орчинд шударга байдлыг төлөвшүүлэх зорилготой нөлөөллийн аян юм. Арга хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 150 гаруй охид оролцсон юм. Мөн 2013 оноос www.ekids.mn цахим хуудсыг ажиллуулж, Төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбож олон нийт хүүхэд залуучуудад зориулан цахим орчны ёс зүйтэй хэрэглээ, цахим орчинд хэрхэн аюулгүй оролцох, шударга байдлыг төлөвшүүлэх ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгох талаарх мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг тогтмол нийтэлж байна. Тус сайтад цахим орчны зохистой хэрэглээний зөвлөмж, гарын авлага зэрэг 135 видео шторк, 275 постер, 251 нийтлэл мэдээлэл байршуулсан.
----	---	--	-----------------------	---	---------------------------------	----	------	------	--

9.5. Төрийн албанд ёс зүйн шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж ажилд авах соёлыг төлөвшүүлж, тогтолцоог бүрдүүлнэ.

17	9.5.2. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна.	9.5.2.1. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах	Зохион байгуулсан арга хэмжээ	-	150 Улсын төсөв, бусад эх үүсвэр	10	Үгүй	100%	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia portal) болон e-Mongolia app-аар дамжуулан АТГ-т санал, хүсэлт, гомдол мэдээлэл өгөх суваг нээж, шүгэл үлээхийг хамгаалах боломжийг бүрдүүлсэн. Мөн төрийн үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх боломж болон түүний ач холбогдлын талаар олон байгууллагын болон харьяа байгууллагын цахим хуудсаар олон нийтэд сурталчлан таниулж байна.
----	---	---	-------------------------------	---	----------------------------------	----	------	------	--

10. Гамшгаас хамгаалах, онц байдлын үеийн үйл ажиллагаа болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдүүлнэ.

10.2. Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хариу арга хэмжээний санхүүжилт, хандив, тусламжийн үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох бодлогын баримт бичгийг боловсруулж, гүйцэтгэлийн мөрөөр авч хэрэгжүүлэх хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

18	10.2.3. Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хандив, тусламжийг бүртгэх, зарцуулалтыг ил тод болгох, хяналт тавих олон нийтэд нээлттэй цахим системийг нэвтрүүлнэ.	10.2.3.1. Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хандив, тусламжийг бүртгэх, зарцуулалтыг ил тод болгох, хяналт тавих олон нийтэд нээлттэй цахим систем нэвтрүүлэх цахим системийг боловсронгуй болгох	Цахим системийг үүсгэсэн, сайжруулалт	-	600 Улсын төсөв, бусад эх үүсвэр	1	Үгүй	100%	Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хандив, тусламжийг бүртгэх, зарцуулалтыг ил тод болгох ажил нь тухайн асуудлыг хариуцсан байгууллагын чиг үүрэг бөгөөд тус үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн систем шинээр нэвтрүүлэх бол Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас зөвлөмж, дүгнэлт гаргуулдаг. 2025 оны байдлаар зөвлөмж, дүгнэлт гаргуулахаар хүсэлт ирүүлээгүй болно. Харин Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана гэж заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмын хүрээнд тухайн байгууллагын төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг олон нийтэд ил тод болгож байгаа эсэхийг улирал тутам үнэлж, Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээр олон нийтэд тухай бүр мэдээллэж байна. 2025 оны байдлаар Онцгой байдлын Ерөнхий газар төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээгээр 85%-ийн гүйцэтгэлтэйгээр үнэлэгдсэн болно.
----	--	--	---------------------------------------	---	----------------------------------	---	------	------	---

10.3. Ирээдүйд тулгарч болохгүй нөхцөл байдлын үеийн авлигын эрсдэлийг тооцоолон хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, учирч болох хор хохирлоос урьдчилан сэргийлнэ.

19	10.3.3. Шинжлэх ухаан, технологи, инновацыг нэвтрүүлэх байдлаар авлигын эрсдэлийг тодорхойлдог болно.	10.3.3.1. Шинжлэх ухаан, технологи, инновацыг нэвтрүүлэх байдлаар авлигын эрсдэлийг тодорхойлох	Шинжлэх ухааны шинэ арга, аргачлал, технологи, инновацыг ашигласан авлигын эрсдэлийн үнэлгээ	-	340 Улсын төсөв, бусад эх үүсвэр	1	Үгүй	90%	<p>Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банк хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Дэлхийн банкны эзэлийн санхүүжилтээр Ухаалаг засаг II төслийг хэрэгжүүлж, хариуцагчаар тус яам ажиллаж байгаа ба Авлигатай тэмцэх газрын хариуцдаг Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн системийг шинэчлэх, тоног төхөөрмжийг сайжруулах төслийг АТГ-тай хамтран хэрэгжүүлж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем болон тоног төхөөрөмж" төслийн гүйцэтгэгчээр Ай ти зон ХХК шалгарсан ба Мэдүүлэг бүрдүүлэлт, хяналт шалгалтын систем, түүний өгөгдлийн сан, техник хангамжийг бүрэн шинэчилж дууссан ба 2025.01.02-ны өдрөөс эхлэн Авлигатай тэмцэх газрын iad.iaac.mn, search.iaac.mn, smart.iaac.mn, хасхот.iaac.mn шинэчилсэн системүүд ажиллахад бэлэн болсон.</p> <p>Дээр дурдсан "хасхот.iaac.mn" системийн хөгжүүлэлтийн хүрээнд мэдүүлэг гаргагчийн ХАСХОМ, ХАСУМ, мэдэгдэл, тайлбар, тэдгээрийн хөрөнгө, орлогын мэдүүлгүүдийг хураангуйлан харах, харьцуулан шинжлэх, эрсдэлийг тооцоолж үнэлэх зэрэг хөгжүүлэлтийн ажлуудыг гүйцэтгэж байна Эдгээр ажлын үр дүнд Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалтын албан тушаалтнууд мэдүүлэг гаргагчдын эрсдэлийг урьдчилан тооцоолон үнэлж, харах боломж бүрдэх юм.</p>
Нийт								92.60%	